

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай тэмцэх газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МНБ	Мэргэшсэн нягтлан бодогч
МУ	Монгол Улс
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОХУ	Оросын холбооны улс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАГ	Төрийн аудитын газар
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/54 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан боловсруулах журам, бүтэц”, УАГ-ын Стратегийн удирдлагын газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааг нэгтгэн тайлагнаж байна. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгуулалт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2017 онд төрийн аудитын байгууллагын системийн хэмжээгээр дэвшүүлсэн “Эрх зүйн шинэчлэл, сахилга хариуцлагыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд нийт 37 ажил төлөвлөж, төлөвлөгөөт ажлуудыг бүрэн гүйцэтгэлээ.



Тус төрийн аудитын газар нь тайлант онд батлагдсан төсөв, орон тооны хүрээнд 12 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр 12 ажилтныг чөлөөлсний 11 нь буцаан томилогдож, 1 ажилтыг томилох тушаал гараагүй байна.

Гүйцэтгэлийн, нийцлийн, санхүүгийн, нийтлэг үйлчилгээний алба гэсэн албадын зохион байгуулалттай, дарга, тэргүүлэх аудитор -1, аудитын хэлтсийн дарга буюу аудитын менежер -1, ахлах аудитор-3, аудитор -6, жолооч -1 гэсэн бүтэцтэйгээр 12 хүн, хуанлийн 250 өдөр буюу 3000 хүн/ өдөр ажиллахаас нийт 308 өдөр, 3464 хүн/өдөр ажиллаж, 58 өдөр буюу 464 хүн/өдөр илүү зарцуулжээ.

Тайлант хугацаанд Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 3 гүйцэтгэлийн аудит, 4 нийцлийн аудит болон 304 байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэсэн бол аймгийн ИТХ-ын захиалгаар 3, өөрийн төлөвлөгөөгөөр 1 гүйцэтгэлийн аудит, 4 эрсдэлийн аудит, 1 давтан аудитыг хийж гүйцэтгэлээ.

2016 оноос шилжиж ирсэн 1 гүйцэтгэлийн аудит, 1 эрсдэлийн аудитыг дуусган дүн, мэдээг 2017 оны статистик мэдээнд нэгтгэн оруулав.

2017 онд хийгдсэн аудитуудаар нийт 40,518.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн, санхүүгийн тайлангийн аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 6,545.8 сая төгрөгийн алдааг залруулж, 839,6 сая төгрөгийн төлбөрийн акт, 6,785.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага бичин, 26,348.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласнаар 817,4 сая төгрөгийн акт, 5,515.4 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлээд байна.



2016 оноос шилжин ирсэн акт, албан шаардлагын дүнг нэгтгэн авч үзвэл тайлант онд нийт 822,1 сая төгрөгийн акт, 6,611.8 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг хангаснаар акт 97.3 хувийн, албан шаардлага 81.2 хувийн биелэлттэй тайлагнагдлаа.

2017 онд хийж гүйцэтгэсэн аудитуудын дүнд үндэслэн нийт 460 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсний 81.7 хувь нь биелэгдсэн байна.

Холбогдох хууль, тогтоомж, стандартыг ханган ажиллаагүйгээс санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь их хэмжээний алдаа, зөрчилтэй илэрхийлэгдэж, “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгөгдсөн болон аудитад шаардлагатай баримт, материалыг хугацаанд нь ирүүлээгүй, их хэмжээний материаллаг зөрчил гаргасан, шилэн дансны нэгдсэн санд байршуулах мэдээллийг бүрэн байршуулаагүй зэрэг нийт 33 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлснээс 31-ийг нь бүрэн хангасан хариу ирүүлээд байгаа бөгөөд 2 нь хэрэгжих хугацаа болоогүй тул дараа онд шилжээд байна.

2017 онд нийт 5,487.9 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн, харилцагчид хүлээн зөвшөөрснөөр төсвийн зардлын 1 төгрөгт ногдох үр өгөөж 25,2 төгрөгт хүрлээ.

Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 304 байгууллага, аж ахуйн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулахаар төлөвлөснөөс өөрийн аудитор, шинжээчдээр 224, хараат бус аудитын 5 компаниар 80 байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгүүллээ.

Аудитад хамрагдсан 304 байгууллагын 19-д нь Ерөнхий аудиторын тушаалаар итгэл үзүүлж, 156 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 129 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргасан байна.

Нийт дүгнэлт гаргасан байгууллагын 126-д нь “Зөрчилгүй”, 3-д нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,874.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс бүртгэл, тайлагналтай холбоотой 6,545.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 58,5 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,741.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 296 зүйлийн зөвлөмж хүргүүллээ.

Актын биелэлт: Өмнөх оны үлдэгдлээс 3.2 сая төгрөг, тайлант хугацаанд тогтоогдсон актаас 37,9 сая төгрөгийг төлүүлснээр актын биелэлт 70.2 хувьтай тайлагнагдсан бөгөөд 17.4 сая төгрөгийн актын төлбөр дараа онд шилжээд байна.

Албан шаардлагын биелэлт: Тайлант хугацаанд санхүүгийн аудитаар нийт 1,741.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн бөгөөд өмнөх оноос шилжин ирсэн 103,8 сая төгрөгийн, тайлант хугацааны 1,463.4 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлснээр 90.0 хувийн биелэлттэй тайлагнагдлаа. 174.0 сая төгрөгийн албан шаардлага дараа онд шилжээд байна.




График 4



Санхүүгийн тайлангийн аудитаар 4 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч, бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

Зөвлөмжийн хэрэгжилт: Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 270 зөвлөмж өгсөнөөс 233-ыг буюу 86,2 хувийг нь хэрэгжүүлсэн дүн, мэдээтэй тайлагнагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар давхардсан тоогоор төрийн аудитын байгууллагын 16 хүн, 92 өдөр ажиллаж, 52.8 сая төгрөгийн зардал гарган, ажлын цар хүрээ, ачааллаас шалтгаалан 266 цаг илүү ажилласан бөгөөд 1,365.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагчаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Өөрийн аудиторуудын гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын бүх үе шатны ажлыг СТАУС программаар гүйцэтгэсэн болно.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

2017 онд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 3, аймгийн ИТХ-ын захиалгаар 3, өөрийн төлөвлөгөөгөөр 1 зэрэг нийт 7 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитад суурилсан 4 эрсдэлийн аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд 2016 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах зорилгоор 1 давтан аудит хийж, өмнөх оноос шилжин ирсэн 1 гүйцэтгэлийн аудит, 1 эрсдэлийн аудитыг гүйцээн дүн, мэдээг гүйцэтгэлийн аудитын дүнд оруулан тайлагнаж байна.

График 5

Актын биелэлт: Өмнөх оны үлдэгдэл 3,3 сая төгрөг, тайлант оны 763,9 сая төгрөг зэрэг нийт 767.2 сая төгрөгийн актаас 760.1 сая төгрөгийн төлбөрийг барагдуулснаар актын биелэлт 99.1 хувьтай тайлагнагдсан бөгөөд 7.1 сая төгрөгийн актын төлбөр дараа онд шилжээд байна.





График 6



Албан шаардлагын биелэлт: Урьд оноос шилжиж ирсэн 625.0 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант хугацаанд өгөгдсөн 3,947.7 сая төгрөгийн албан шаардлагаас 2,975.7 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлж, 972.0 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт дараа онд шилжсэнээр 78.7 хувийн биелэлттэй тайлагнагдлаа.

Зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оны үлдэгдэл 8, тайлант оны 150 зэрэг нийт 158 зөвлөмжөөс 89.2 хувь буюу 125-ыг нь хэрэгжүүлсэн бөгөөд 33 зөвлөмжийн хэрэгжилт дараа онд шилжээд байна.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр 3,812.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн, 23 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч, хэрэгжилтийг бүрэн хангасан бөгөөд давхардсан тоогоор 65 хүн, нийт 123 өдөр, үүнээс 144 цаг илүү ажиллан, 88,5 сая төгрөг зарцуулжээ.

Хийж гүйцэтгэсэн аудит тус бүрийн талаар товч дурдвал:**1.ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр:**

- “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн”

Гүйцэтгэлийн аудитаар “Төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд тавигдах техникийн хяналт хангалтгүйгээс бүрэн хэрэгжээгүй ажлыг ашиглалтад хүлээн авах, санхүүжилтийг гүйцэтгэсэн ажлын хувь хэмжээнээс илүү олгох зөрчил оршсоор байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Уг аудитаар илрүүлсэн нийт 917.4 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах 9 албан шаардлага өгч, холбогдох албан тушаалтнуудад 15 зүйлийн зөвлөмж хүргүүлснээс албан шаардлагын 83,8 хувийг, зөвлөмжийн 73,3 хувийг биелүүлсэн байна.

Аудитад 4 хүн, 99 хүн/өдөр, үүнээс 22 цаг илүү ажиллаж, 8,6 сая төгрөг зарцуулан, 863.9 сая төгрөгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв.

- *Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилт, үр дүн*

Гүйцэтгэлийн аудитаар нийт 5,999.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 19,5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, бүртгэл, тайлагналтай холбоотой 5,979.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласнаар албан шаардлагыг биелүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй тул дараа онд шилжээд байна. Аудитад 6 хүн, 48 хүн/өдөр ажиллаж, 4,6 сая төгрөг зарцууллаа.

- *Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн*

Гүйцэтгэлийн аудитаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, батлан, хянахгүй байгаа нь батлагдсан санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг дагуулж байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Аудитаар илрүүлсэн нийт 39.9 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах 2 албан шаардлага, 10 зөвлөмж хүргүүлснээс албан шаардлагын биелэлт 27,1 хувьтай, зөвлөмжийн биелэлт 80.0 хувьтай тайлагнагдсан байна.

Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэснээс зөрчил гарах нөхцөлийг бүрдүүлсэн 2 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

Аудитад 4 хүн, 95 хүн/өдөр, үүнээс 20 цаг илүү ажиллаж, 8,9 сая төгрөг зарцуулан, 25.0 сая төгрөгийн үр өгөөж тооцон, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

2. Аймгийн ИТХ-ын захиалгаар:

- “Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны үр дүн”

Гүйцэтгэлийн аудитаар “Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэж, холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Аудитаар илрүүлсэн нийт 46.1 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах 3 албан шаардлага, 10 зөвлөмж хүргүүлэн, биелэлтэд хяналт тавин ажилласнаар албан шаардлагын 88,9 хувийг, зөвлөмжийн 90,0 хувийг бүрэн биелүүлсэн байна.

Аудитад 4 хүн, 53 хүн/өдөр, үүнээс 4 цаг илүү ажиллаж, 4,4 сая төгрөг зарцуулан, 16.6 сая төгрөгийн үр өгөөж тооцон, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

- “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”

Аудитаар “Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах, зээлийг хугацаанд нь төлүүлэхийн тулд зээлийг олгосны дараа үр нөлөө муутай хяналт, шалгалт хийх бус олгохоос өмнөх судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг бодитой болгох, хууль, эрх зүйн чадамж бүхий барьцаа хөрөнгө авч үлдэх, зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах зэрэг үр нөлөө бүхий арга хэмжээг холбогдох байгууллагуудаас нэгдсэн бодлого барьж хэрэгжүүлэх нь зүйтэй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Аудитаар илрүүлсэн нийт 1,165.9 сая төгрөгийн зөрчлөөс 3.6 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 1,162.3 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах 3 албан шаардлага, 18 зөвлөмж хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласнаар актыг бүрэн биелүүлж, албан шаардлага 79,7 хувийн, зөвлөмж 83,3 хувийн биелэлттэй тайлагнагдсан болно.

Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэснээс зөрчил гарах нөхцөлийг бүрдүүлсэн 5 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

Аудитад 9 хүн, 274 хүн/өдөр, үүнээс 30 цаг илүү ажиллаж, 17.0 сая төгрөг зарцуулан, 761.0 сая төгрөгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

- “Цахим сургууль-Цахим сургалт” хөтөлбөрийн үр дүн

Гүйцэтгэлийн аудитаар “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулаагүй бөгөөд хэрэгжилт, үр дүнд тавих хяналт- үнэлгээ хангалтгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн бөгөөд зөрчлийг таслан зогсоох 5 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн нь 80,0 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Аудитад 4 хүн, 53 хүн/өдөр, үүнээс 8 цаг илүү ажиллаж, 4,0 сая төгрөг зарцуулсан байна.

3. Өөрийн төлөвлөгөөгөөр:

- “Аймаг хөгжүүлэх сангаас олгосон зээл, түүний эргэн төлөлт, зарцуулалтын үр дүн, үр нөлөөт байдал”

Гүйцэтгэлийн аудитаар “Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийн нийт эх үүсвэрийн 90,2 хувь нь хугацаа хэтэрсэн авлага хэлбэрт шилжсэнээс дараагийн төслүүдийг дахин санхүүжүүлэх боломжгүй болсон байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өглөө.

Аудитаар илрүүлсэн нийт 1,975.3 сая төгрөгийн зөрчлөөс 755.3 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 1,220.0 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах 1 албан шаардлага, 8 зөвлөмж хүргүүлснээс акт 99.3 хувийн, албан шаардлага 59,0 хувийн, зөвлөмж 75,0 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Уг аудит нь он дамжиж ирсэн тул тайлант онд 3 хүн 18 хүн/өдөр ажиллан, 2.8 сая төгрөг зарцуулж, 1,975.3 сая төгрөгийн үр өгөөж тооцон, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

- *“Цант-Орхон ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн”*

Гүйцэтгэлийн аудитаар *“Төлөөлөн удирдах зөвлөл, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт сул байгаагаас үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд оршиж буй зөрчил арилаагүй байна”* гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 134.1 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах 3 албан шаардлага, 16 зөвлөмж хүргүүлэн, биелэлтэд хяналт тавин ажилласнаар албан шаардлагыг 98,5 хувиар, зөвлөмжийг 81,3 хувиар биелүүлсэн байна.

Аудитад 3 хүн 53 хүн/өдөр, үүнээс 8 цаг илүү ажиллаж, 4,7 сая төгрөг зарцуулан, 134.1 сая төгрөгийн үр өгөөж тооцон, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

- *“Сүхбаатар сумын 12 жилийн бүрэн дунд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн” /Эрсдэлийн аудит/*

Өмнөх оноос дамжсан уг эрсдэлийн аудитаар *“Сүхбаатар сумын бүрэн дунд сургуулиуд ажлын үр дүнг үнэлэхгүйгээр ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон, батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан байна”* гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Аудитаар нийт 156.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 1.3 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 154.8 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 14 зөвлөмж хүргүүлснээс актыг бүрэн барагдуулж, албан шаардлага 92,2 хувийн, зөвлөмж 85,7 хувийн биелэлттэй тайлагнагдлаа.

Аудитад 6 хүн, 36 хүн/өдөр ажиллаж, 4,1 сая төгрөг зарцуулан, 7.9 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв.

- *“Өрхийн ЭМТ-үүдийн 2016 оны удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа” /Эрсдэлийн аудит/*

Эрсдэлийн аудитаар *“Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хууль, дүрмийн дагуу зохион байгуулаагүй бөгөөд төсвийн гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна”* гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Аудитаар нийт 5.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1.0 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 4.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 12 зөвлөмж хүргүүлэн, биелэлтэд хяналт тавьж ажилласнаар актыг бүрэн биелүүлж, албан шаардлагын биелэлт 81,0 хувьтай, зөвлөмжийн биелэлт 75.0 хувьтай тайлагнагдсан байна.

Аудитад 3 хүн, 55 хүн/өдөр, үүнээс 10 цаг илүү ажиллан, 4.6 сая төгрөг зарцуулж, 4.2 сая төгрөгийн үр өгөөж тооцон, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

- *“Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа” /Эрсдэлийн аудит/*

Уг аудитаар *“Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүйгээс ихээхэн хэмжээний санхүүгийн зөрчил оршиж байна”* гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Аудитаар сумдын ЭМТ-ийн дэргэдэх эмийн сангууд нь эмийн тайлан гаргадаггүй, борлуулалын орлогыг бүртгэлд тусгадаггүй зөрчил нийтлэг байдлаар оршиж байсныг аудитын явцад нөхөн хийлгүүлж, нийт 137.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн, 2.5 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 134.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 15 зөвлөмж хүргүүлснээс актыг бүрэн биелүүлэн, албан шаардлагыг 80,3 хувиар, зөвлөмжийг 80.0 хувиар биелүүлсэн болно.

Эмийн сангийн орлогыг бүртгэл тайланд тусгаагүй, эмийн тайлан гаргаагүй болон аудитад шаардлагатай баримт, материалыг хугацаанд нь ирүүлээгүй 13 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

Аудитад 4 хүн, 75 хүн/өдөр, үүнээс 24 цаг илүү ажиллаж, 5,3 сая төгрөг зарцуулан, 2.5 сая төгрөгийн үр өгөөж тооцон, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

- *“Шаамар сумын МСҮТ-ийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа” /Эрсдэлийн аудит/*

Эрсдэлийн аудитаар *“Тус МСҮТ нь хөрөнгө, бараа материалыг холбогдох тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн бөгөөд дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг хэтрүүлэн зарцуулсан байна”* гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Эрсдэлийн аудитаар нийт 46.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 0.2 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 46.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 12 зөвлөмж өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласнаар актыг бүрэн биелүүлж, албан шаардлага 97,6 хувийн, зөвлөмж 83,3 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Аудитад 3 хүн, 40 хүн/өдөрт 4.1 сая төгрөг зарцуулан, 10.8 сая төгрөгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

- *“Мандал сум дахь Зүүнхараа Политехникийн коллежийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа” /Эрсдэлийн аудит/*

Эрсдэлийн аудитаар *“Батлагдсан төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэж, цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд гүйлгэн зарцуулсан байна”* гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Аудитаар 68.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 6 зүйлийн зөвлөмж хүргүүлснээс албан шаардлагын биелэлт 75,4 хувьтай, зөвлөмжийн биелэлт 83,3 хувьтай тайлагнагдсан байна.

Аудитад 3 хүн, 40 хүн/өдөр ажиллан, 4.0 сая төгрөг зарцуулж, 11.3 сая төгрөгийн үр өгөөж тооцон, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

- “Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн “Давтан аудит”

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүнд өмнөх онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах зорилгоор давтан аудит хийж гүйцэтгэв.

Өмнө онд хийсэн гүйцэтгэлийн аудитын мөрөөр удирдлага, зохион байгуулалтын ихээхэн хэмжээний арга хэмжээ авч ажилласан боловч акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан тухай хариу ирүүлээд байна.

Аудитад 5 хүн, 92 хүн/өдөр, үүнээс 18 цаг илүү ажиллаж, 11.0 сая төгрөг зарцууллаа.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар

Тайлант хугацаанд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 4 нийцлийн аудит хийж гүйцэтгэв.

График 7

Актын биелэлт: Өмнөх оноос шилжсэн актын үлдэгдэл байхгүй ба тайлант хугацаанд тогтоосон 20,9 сая төгрөгийн актыг бүрэн барагдуулаад байна.

Албан шаардлагын биелэлт: Өмнөх оноос шилжиж ирсэн албан шаардлагын үлдэгдэл 367,6 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, тайлант хугацаанд өгөгдсөн 1,200.1 сая төгрөгийн албан шаардлагын 1,076.3 саяг буюу 89,7 хувийг нь биелүүлээд байна.





График 8

Зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оноос шилжиж ирсэн 7 зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант онд 40 зөвлөмж өгсөний 65.0 хувийг буюу 26-г нь хэрэгжүүлж, 14 зөвлөмжийн хэрэгжилт дараа онд шилжлээ.



Нийцлийн аудитын дүнгээр 309,7 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагчаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд 6 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгсөний 4-ийг биелүүлсэн талаар хариу ирүүлж, 2 нь хэрэгжих хугацаа болоогүй учир дараа онд шилжээд байна. Давхардсан тоогоор 29 хүн, нийт 80 өдөр, үүнээс 54 цаг илүү ажиллан, 43,4 сая төгрөг зарцуулжээ.

Хийж гүйцэтгэсэн аудит тус бүрийн талаар товч дурдвал:

- “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт”

Нийцлийн аудитаар “ОНХС-гийн хөрөнгийн тодорхой хэсгийг машин, техник, тоног төхөөрөмж худалдан авах, урсгал зардлыг санхүүжүүлэх зэргээр тухайн

байгууллагын төсвийн цоорхойг нөхөх эх үүсвэр болгон, хэт жижиглэн зарцуулж байгаа нь тус сангийн зарцуулалтын үр өгөөжийг бууруулж байна.” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Аудитаар аймгийн хэмжээнд нийт 1,147.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 20.9 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлөх 2 төлбөрийн акт тогтоож, 1,126.7 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй ажиллах 15 албан шаардлага, 14 зөвлөмж хүргүүлэн, биелэлтэд хяналт тавьж ажилласанаар актыг бүрэн, албан шаардлагыг 86,3 хувиар зөвлөмжийг 78,6 хувиар биелүүлсэн байна.

Аудитад 9 хүн, 138 хүн/өдөр, үүнээс 20 цаг илүү ажиллаж, 14.4 сая төгрөг зарцуулан, 309.7 сая төгрөгийн үр өгөөж тооцсоныг харилцагч байгууллага хүлээн зөвшөөрлөө.

- *“Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл”*

Нийцлийн аудитаар *“Аймаг, сумдын Сонгуулийн хорооноос сонгуулийн зардлын гүйцэтгэлд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар зардлын гүйлгээ хийсэн, зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд гарсан байна.”* гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

73.4 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 10 зөвлөмж хүргүүлснийг бүрэн биелүүлсэн байна.

Аудитад 5 хүн, 80 хүн/өдөр ажиллан, 5.2 сая төгрөг зарцуулжээ.

- *“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”*

Нийцлийн аудитаар *“Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, аж ахуйн нэгжүүд шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих 102,772.0 сая төгрөгийн мэдээллээс 93,879.6 сая төгрөгийн буюу 91.3 хувийг мэдээлсэн байна”* гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Нийцлийн аудитаар зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах 6 зөвлөмж хүргүүлснийг 83,3 хувиар биелүүлсэн бөгөөд мэдээлбэл зохих мэдээллийн 50,0- иас дээш хувийг мэдээлээгүй 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн ТЕЗ-д хүргүүлэн, биелэлтийг хангаж ажиллалаа.

Аудитад 10 хүн, 252 хүн/өдөр, үүнээс 16 цаг илүү ажиллаж, 14,3 сая төгрөг зарцуулсан байна.

- *“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт”*

Нийцлийн аудитаар *“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт буюу хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, боловсруулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэх үйл ажиллагаа хангалтгүй байна”* гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Аудитад шаардлагатай баримт, материалыг ирүүлээгүй Ерөө, Хушаат сумдын Засаг дарга нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 10 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй тул дараа онд шилжээд байна.



Аудитад 5 хүн, 121 хүн өдөр, үүнээс 18 цаг илүү ажиллаж, 9,5 сая төгрөг зарцууллаа.

Тав. Аймгийн ИТХ-ын хүсэлтээр хийсэн аудит болон ИТХ-тай хамтран ажилласан талаар

Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн 19 аудитын тайлан, дүнг аймгийн ИТХ-ын даргад цаасаар, төлөөлөгчдөд цахимаар хүргүүлсэн бөгөөд аймгийн ИТХ-ын захиалгаар дараах 3 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэн, нийт 3,2 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.208,4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага бичиж, 33 зүйлийн зөвлөмж өгөн, биелэлтэд хяналт тавин ажиллалаа.

ИТХ-ын захиалгат аудитиудад 17 хүн, 380 хүн/ өдөр ажиллаж, 10,0 сая төгрөг зарцуулсан бөгөөд, нийт 777,6 сая төгрөгийн үр өгөөж тооцон, харилцагчдаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд ” Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан, дүн”-г 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдөр аймгийн ИТХ-ын даргад цаасан сууриар, бусад төлөөлөгчдөд цахимаар хүргүүлж, танилцуулсан бөгөөд 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр хуралдсан аймгийн ИТХ-ын нэгдсэн хуралдаанд оруулж, хэлэлцүүлэв.



Уг хуралдаанаар орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүн, ашиг, алдагдал, өр, авлагын үзүүлэлтүүд, аймаг, сум хөгжүүлэх сангаас олгосон их хэмжээний хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл зэрэг анхаарал татахуйц асуудлуудыг нэгтгэн танилцууллаа.

Төрийн аудитын тухай хуулийн 15.2.4-д заасан бүрэн эрхийн дагуу “Аймгийн 2018 оны төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх санал”-ыг ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлсний дүнд усны төлбөрийг нэмэгдүүлэх нөөц боломжоор орлогыг 197,6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, авто машин худалдан авахаар өргөн мэдүүлсэн 47,0 сая төгрөгийн зардлыг хасуулж, цэцэрлэг, сургуулийн засварын ажилд зарцуулахаар өөрчлөлт оруулан, батлуулсан болно.

Зургаа. Дотоод ажлын талаар

Архив, бичиг хэрэг: 2017 онд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 35 тушаал гарч, явсан бичиг 266, албан тоотоор ирсэн бичиг 52, цахимаар ирсэн бичиг 77 тус тус бүртгэгджээ.

Нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийгдэх аудит болон бүтэц зохион байгуулалт, хууль, эрхийн актуудын шинэчлэл, өөрчлөлттэй холбоотойгоор 19 судалгаа, санал, хүсэлтийг ҮАГ-ын холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.

МУ-ын Ерөнхий аудиторов 2017 оны 04-р сарын 07-ны өдрийн А/59 дугаар тушаалын дагуу байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тамга тэмдэг, хэвлэмэл хуудсуудыг шинээр хийлгэж, ашиглаж байгаа ба тухайн сард хийж гүйцэтгэсэн ажлын тайланг сар бүрийн 25-нд, хүний нөөцийн судалгааг сар бүрийн сүүлийн 7 хоногийн “Пүрэв” гаригт УАГ-т мэдээлснээс гадна холбогдох газруудаас зохион байгуулсан цахим хуралд тухай бүр оролцов.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2016 оны ирсэн, явсан бичиг, дарга, тэргүүлэх аудиторов тушаал болон бусад дотоод бичиг баримтууд, аудитын тайлан, ажлын баримтууд, санхүүгийн баримтуудыг холбогдох журмын дагуу архивын нэгж болгон үдэж, цэгцлэн, нийт 12 хавтас материалыг байгууллагын архивт хүлээлгэн өглөө. Байгууллагын архивын баримт, материалуудын хэмжээ жил ирэх бүр өсөн нэмэгдэж, хадгалах, шкаф, шүүгээний хүрэлцээ муу байгаа учир архив, бичиг хэргийн өрөөний нэг ханыг эзэлсэн архивын шүүгээ, тавиурыг шинээр хийлгэж, байршуулан, хаягжуулснаар архивын баримт, материалын эмх, цэгц сайжирсан байна.




Хүний нөөц: Нийт 12 ажилтны 75,0 хувь нь тус байгууллагад 5-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ба 50,0 хувь нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй.

Тайлант онд бүх ажилтнууд төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрэм, шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөн ажилласнаар ёс зүйн зөрчил гаргасан ажилтан байхгүй бөгөөд 2016 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд авч, нэгтгэн тайланг хүргүүлж, аудит хийж гүйцэтгэх тухай бүр ашиг, сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг аудиторуудаар гаргуулж хэвшсэн болно.

2017 онд дарга, тэргүүлэх аудиторов зүгээс төрийн жинхэнэ албан хаагч 10 ажилтантай үр дүнгийн гэрээ, төрийн үйлчилгээний албан хаагч 1 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, дүгнэснээр үр дүнгийн гэрээг 5 ажилтан “А”, 4 ажилтан “В”, 1 ажилтан “С” үнэлгээтэй дүгнүүлсэн бол төрийн үйлчилгээний албан хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг “хангалттай-сайн” үнэлгээтэй үнэлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, Ерөнхий аудиторов орон нутаг хариуцсан орлогч С.Бүрэнбат нарын хооронд байгуулж, биелэлтийн тайланг гаргаж 2017 оны 12 сарын 25-ны өдөр хүргүүлэв.

Байгууллагын ил тод байдлыг хангах: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь өөрийн байгууллагын танилцуулга, үйл ажиллагаа, хийж гүйцэтгэсэн аудитын дүн, тайланг хэрэглэгчдэд нээлттэй, ил тод мэдээлэх зарчмын хүрээнд 2017 онд 19 аудитын тайлан, үйл ажиллагаатай холбоотой 18 мэдээллийг AUDIT.MN цахим хуудсанд байршуулсан бөгөөд төсвийн төлөвлөлт, зарцуулалт болон холбогдох бусад үзүүлэлтүүд зэрэг нийт 141 мэдээллийг



хуулийн хугацаанд нь SHILENDANS.GOV.MN нэгдсэн цахим хуудсанд мэдээлж байна.

Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга, бүх гишүүдэд цахимаар, аймгийн Засаг дарга болон аудит хийгдсэн байгууллагуудад цаасан сууриар хүргүүлж байна.

Сэлэнгийн мэдээ сонин, Миний монгол кабелийн телевиз зэрэг орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, аудитын тайлан, дүнг цахимаар өгч байгаа бөгөөд Миний Монгол телевизийн “Иргэдээ сонсоё” шууд нэвтрүүлэгт оролцон, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг танилцуулж, иргэдийн сонирхсон асуултад хариулт өглөө. Хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд тус байгууллагад ажиллаж буй бүх ажилтан, албан хаагчдын товч танилцуулгыг самбараар, нийтэд мэдээлж байна.



Шагнал, урамшуулал: 2017 онд төрийн одон, медаль, салбарын “Тэргүүний ажилтан”-аар шагнуулахаар 5, аймгийн ИТХ, Засаг даргын шагналаар шагнуулахаар 2, аймгийн 2017 оны тэргүүний ажилтнаар шалгаруулахаар 1 зэрэг нийт 8 ажилтны тодорхойлолтыг холбогдох байгууллагуудад хүргүүлснээс дараах 6 ажилтан шагнагдлаа. Үүнд:

- “Санхүү, банкны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр: Ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, С.Баасансүрэн, аудитор Ц.Отгонбаяр нар,
- Аймгийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл” –өөр: Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа,
- Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр аудитор Ц.Уртнасан,
- Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Сэлэнгэ салбарын 2017 оны “Шилдэг санхүүч”-ээр ахлах аудитор Б.Наранчимэг.



Ажилтнуудын нийгмийн асуудал: Шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу батлагдсан санхүүжилт, төсвийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:


- Бүх ажилтнуудыг мэргэжлийн эмчийн “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх” үзлэг, биохимийн шинжилгээнд хамруулж, зөвлөгөө өгүүлэв.
- Ердийн галлагаатай орон сууцанд амьдардаг 2 ажилтанд түлээ, нүүрсний хөнгөлөлт 95,0 мянган төгрөг олгов.
- Нийт ажилтнуудын хоол, унааны хөнгөлөлтөд сар бүр, тус бүр 30,0 мянган төгрөг, нийт 4,3 сая төгрөг олгов.



- Бүх ажилтнуудыг ОХУ-ын “Цурхайт нуур”-ын амралт, Улан-Удэ хотоор 2 хоног аялуулав.

Сургалт, зөвлөгөөн: Дарга, тэргүүлэх аудиторын өөрийн болон бусад ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх талаар байнга анхааран ажиллаж, мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөг батлан, ажилтнуудын ажлын байран дахь сургалтыг хэрэгжүүлснээс гадна 2017 онд холбогдох байгууллагуудын хамтарсан, дотоодод зохион байгуулсан зэрэг 13 удаагийн, 132,25 хүн өдрийн сургалтад давхардсан тоогоор 61 хүнийг /жолоочоос бусад/ хамруулсан болно. Үүнд:

- Дархан-уул аймагт зохион байгуулсан СТАУС программын сургалтад бүх ажилтнууд, / 11 хүн/өдөр /,
- Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, сургалтад дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитын менежер Б.Батмөнх нар, / 4 хүн/ өдөр /,
- Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан Хангайн бүсийн сургалтад бүх ажилтнууд, /33 хүн/ өдөр /,
- Аудиторын сургагч багш бэлтгэх сургалтад аудитор А.Дашбат, / 5 хүн/ өдөр /
- Мэдээллийн нэгдсэн сүлжээний орчинд ажиллах, онлайн хурлын техник, тоног төхөөрөмжийг ашиглах, мэдээллийн аюулгүй байдлын сургалтад аудитор Э.Эрдэнэзул, /3 хүн/өдөр/
- Аймгийн архивын газарт хүсэлт тавьсаны үндсэн дээр “Албан бичиг баримтын хадгалалт, хамгаалалт, стандарт” сэдэвт сургалтад бүх ажилтнууд, /3 хүн/ өдөр/
- Хүний эрхийн үндэсний хорооны Сэлэнгэ аймаг дахь салбарт хүсэлт тавьсаны үндсэн дээр “Хүний эрхийн үндсэн ойлголт” сэдэвт сургалтад бүх ажилтнууд, /3 хүн/өдөр /,
- ММНБИ-ээс зохион байгуулсан “Аудиторын сургалт”-д ахлах аудитор Б.Наранчимэг хамрагдаж, “Аудиторын батламж” авлаа. /7 хүн/өдөр /,
- МНБ-ийн эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтад шинжээч А.Дашбат, Э.Эрдэнэзул, Ж.Цогт, Ц.Уртнасан нар хамрагдан, шалгалт өгч тус бүр 2-4 хичээлийн хөнгөлөлт авсан байна. / 40 хүн/өдөр /
- ММНБИ-ийн тасралтгүй боловсролын сургалтын хүрээнд дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитор Б.Эрдэнэзул нар “Нэгдмэл тайлагнал” сэдэвт 3 өдрийн сургалтад хамрагдав. / 6 хүн/өдөр /,
- АТГ-аас зохион байгуулсан “ХАСУМ, ХАСХОМ гаргах эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудал” сэдэвт онлайн сургалтад ЭБАТ аудитор Ц.Отгонбаяр, / 0,25 хүн/өдөр /,
- Тагнуулын Ерөнхий Газраас зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж” сургалтад дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитын менежер Б.Батмөнх, аудитор Б.Эрдэнэзул, Ц.Отгонбаяр нар, / 2 хүн/өдөр /,
- ХААИС-ийн эдийн засгийн магистрын сургалтад аудитор А.Дашбат суралцаж байна. / 15 хүн/өдөр /,



Аймаг, орон нутаг, ҮАГ-аас зохион байгуулсан соёл, спорт, сургалт, олон нийтийн ажилд амжилт гаргасан талаар:

- ҮАГ-аас зохион байгуулсан “Хангайн бүс”-ийн сургалтад бусад аймгуудын ТАГ-г манлайлан оролцож, “Дурсамж”-аар шагнагдав.
- “Хангайн бүс”-ийн гар бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцож, аудитор А.Дашбат “Шилдэг эрэгтэй тоглогч”-оор шалгарах.
- Аймгийн санхүү-эдийн засгийн байгууллагуудын гар бөмбөгийн тэмцээнд багаараа оролцож “Тэргүүн байр”-т шалгарах.
- Аймаг, орон нутгаас зохион байгуулсан ногоон байгууламж, мод тарих 2 өдрийн ажилд хамт олноороо амжилттай оролцож, 30 мод суулгаж, 1 өдрийн нийтийн цэвэрлэгээний ажилд хамрагдах.



Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт: Тайлант хугацаанд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт Цагааннуур сумын иргэн Н.Отгонсансар, Орхонтуул сумын нийгмийн даатгалын байцаагч Ч.Байгалмаа нарын ирүүлсэн 2 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлэв.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагаанд 219.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас санхүүжилтийг бүрэн авч, гүйцэтгэлээр 217.1 сая төгрөг зарцуулан, 2.2 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдлаа.

Нийт зардлын гүйцэтгэлийн 88,7 хувийг цалин, НДШ-ийн зардал, 11.3 хувийг бараа үйлчилгээний урсгал зардал эзэлж байна.

МУ-ын Ерөнхий аудиторовын 2017 оны 05-р сарын 30-ны өдрийн 1023 дугаар “Эд хөрөнгийн тооллого явуулж, санал ирүүлэх тухай” албан бичиг, байгууллагын 2017 оны хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулж дарга, тэргүүлэх аудиторовын 2017 оны А/07, А/26 дугаар тушаалуудаар томилогдсон “Эд хөрөнгийн тооллогын комисс” 2 удаа хөрөнгийн тооллого явуулж, эзэмшүүлэх картыг шинэчлэн хөтлөв.

Эд хөрөнгийн тооллогын бүртгэл, хөрөнгийн хөдлөлийн тайлан, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл зэргийг ҮАГ-т заасан хугацаанд явуулсан болно. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2016 оны төрийн өмчийн бүртгэл, мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлж, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 95.6 хувьтай дүгнүүлээ.

2017 оны эцэст 105.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 5.6 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө тайлагнагдсан байна.

Тайлант онд Ерөнхий аудиторын өгсөн зөвшөөрөл, эрхийн хүрээнд өөрийн орлогын 12,8 сая төгрөгөөр 5 ширхэг иж бүрэн- суурин компьютер, 2 ширхэг зөөврийн компьютер, 3 ширхэг принтер худалдан авсан бөгөөд Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар 3,7 сая төгрөгийн техник, тоног, төхөөрөмж нийлүүлснийг аудиторуудад картаар эзэмшүүлэн, хөрөнгийн бүртгэлд тусгасан болно.

Байгууллагын эзэмшилд ашиглагдаж байгаа авто машинуудад засвар, үйлчилгээг тухай бүр хийх ажлын хүрээнд Prado-120 машины засвар, үйлчилгээ, сэлбэг, эд анги солиулах ажлуудыг хийж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллав.

Төсвийн гүйцэтгэл, НДШ-ийн болон татварын тайлангуудыг хуулийн хугацаанд нь гарган холбогдох байгууллагуудад хүргүүлж байсан бөгөөд 2016 оны жилийн эцсийн болон 2017 оны улирлын санхүүгийн тайлан, 2018 оны төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдлүүдийг тогтоосон хугацаанд нь УАГ-т хүргүүлэв.

2016 оны санхүүгийн тайланд Улаанбаатар аудит компаниар хөндлөнгийн аудит хийлгүүлж, “**Зөрчилгүй- санал дүгнэлт**” авсан болно.

Найм. Дүгнэлт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь төрийн аудитын байгууллагын системийн хэмжээд тодорхойлсон **“Эрх зүйн шинэчлэл, сахилга хариуцлагыг дээшлүүлэх”** зорилт болон төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний хүрээнд 2017 оны үйл ажиллагаагаа төлөвлөж, төлөвлөгөөт зорилтуудаа бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

ТАЙЛАН БИЧСЭН:

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА